



**ДӨЛГӨӨН ХАЙРХАН УУЛ
АУДИТ ХХК**

Нягтлан бодох бүртгэл, аудит, санхүүгийн
хөндлөнгийн хяналтын байгууллага

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороолол
Ногоон нуур гуламж, 101 барилгын 1204 тоот
Утас: (976) 99055711, 99038602, 70005711
E-mail: dulguunhairhan_audit@mongol.net

2026.04.29 № 26/0464

танай _____-ны № _____-т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн тухай тайлан

Хязгаарлалттай дүгнэлт

Бид “Еврази капитал холдинг ҮЦК” ХХК-ийн /цаашид “Компани” гэх/ 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын, өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, *Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл* хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол “Еврази капитал холдинг ҮЦК” ХХК-ийн 2025 оны 12 сарын 31-ний дуусгавар болсон санхүүгийн тайлан нь бүх материаллаг асуудлаар СТОУС-ын дагуу үнэн зөв, бодитой тайлагнагдсан гэж дүгнэж байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,090,146.50 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

- 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд харилцах данс дахь 12,088.8 мянган төгрөгийн дансны үлдэгдлийг баталгаажуулах боломжгүй аудитаар илгээсэн тулган баталгаажуулалтанд хариу ирээгүй;
- Санхүүгийн тайлан дээрх дансны авлага 471,964.3 мянган төгрөг, өглөг 551,206.4 мянган төгрөг тулган баталгаажуулж тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, насжилтын тайлан бэлтгээгүй байна.
- Санхүүгийн байдлын тайлан дээр 54,886.9 мянган төгрөгийн цалингийн өглөгтэй гэж тайлагнасан бөгөөд үр дүнгийн тайланд цалингийн зардал тусгаагүй, нийгмийн даатгалд тайлагнаагүй байна. Энэ нь ажилтнуудад олгох ёстой цалин хөлс хугацаандаа олгогдоогүй, мөн үүссэн өглөгийн бүртгэл, төлөлтийн хуваарь тодорхой бус байгааг илтгэж байна.

Дээрх зөрчлүүд нь зөрчлүүдийг бүрэн баталгаажуулах, залруулгын үндэслэлийг тайлбарлах хангалттай, зохистой аудитын нотлох баримтыг бид авч чадаагүй тул холбогдох дансад бүрэн хэмжээний аудитын шалгалт хийх боломж хязгаарлагдсан ба энэхүү нөхцөл нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 5.1.5, 12 дугаар

зүйлийн 12.1, 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5 заалтуудыг тус тус нийцээгүй, АОУС 705-д заасан материаллаг боловч бүхэлд нь нөлөөлөхгүй гажуудалд хамаарч байгаа тул *хязгаарлалттай дүгнэлт* гаргасан болно.

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартын дагуу бид хүлээх үүрэг хариуцлагынхаа энэхүү аудитын тайлангийнхаа Аудиторын үүрэг хариуцлага хэсэгт багтаан харуулсан. Бидний хувьд, санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Нягтлан бодогчдын ёс зүйн стандартын шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд бид эдгээр шаардлагын ёс зүйтэй холбоотой бусад үүрэг хариуцлагаа биелүүлсэн болно. Бидний олж авсан нотлолгоо нь бидний гаргасан аудитын хязгаарлалттай санал дүгнэлтийн зохистой үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байна.

Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой асуудлууд

Тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал үүссэн тохиолдол бидэнд ажиглагдаагүй болно. Тус компани нь цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулна гэсэн төсөөллөөр тайлангаа бэлтгэсэн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр, тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Эдгээр асуудлууд нь санхүүгийн тайланг бүхэлд нь хамарсан, аудитын ажлын агуулга болон дүгнэлтийн хэлбэрт тусгалаа олсон бөгөөд эдгээр асуудал дээр бид тусад нь санал дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Бусад мэдээллийн хувьд удирдлага хариуцах бөгөөд жилийн санхүүгийн тайланд орсон боловч бидний гаргасан аудиторын тайланд ордоггүй. Бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилт гаргадаггүй.

Санхүүгийн тайланд засаглах удирдлага болон удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь компанийн удирдлагын үүрэг бөгөөд энэхүү үүрэг, хариуцлагад аливаа алдаа, залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулахтай холбоотой дотоод хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх үүрэг хариуцлагууд багтана.

Ийнхүү санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь компанийн тасралтгүй үргэлжлэх чадварыг үнэлэх, тодруулга гаргах, компаниа татан буулгах эсвэл үйл ажиллагааг нь зогсоох, өөр бусад арга хэмжээ авах зорилгогүй байгаа тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчмын үндэслэлийг ашиглах болон тухайн зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулга хэлбэрээр бэлтгэх зэрэг үүрэг хүлээнэ.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний үүрэг, хариуцлага бол хийж гүйцэтгэсэн аудитдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм. АОУС-аар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилтэй илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй магадлагаа олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.



- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авна. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг орно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаарх ойлголт олж авдаг
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол, тодруулгын зохистой байдлыг үнэлсэн
- Компанийн тасралтгүй байх зарчимд материаллаг тодорхойгүй байдалд эргэлзээ үүссэн бол тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулж, тодруулгад хангалттай дурдаагүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудитын тайлан гарах өдөр хүртэл олж авсан баримт нотолгоондоо үндэслэн дүгнэлтээ гаргасан.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлсон

Энэхүү тайлан нь Монгол улсын “Компанийн тухай” хуулийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болон хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Бид энэхүү Аудитын ажлыг хийж гүйцэтгэж аудитын тайланг бэлтгэсэн болно.



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2025 оны 12 сарын 31-ний байдлаар

	(төгрөгөөр)	
Лавлагаа	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
ХӨРӨНГӨ	-	-
Эргэлтийн хөрөнгө	-	-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	14,412,571.17	12,138,481.33
Авлага	530,732,970.10	530,732,970.10
Бусад санхүүгийн хөрөнгө	508,981,007.20	508,981,007.20
Бараа материал	1,930,456.38	1,930,456.38
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	8,713,531.61	8,713,531.61
Нийт эргэлтийн хөрөнгө	1,064,770,536.46	1,062,496,446.62
Эргэлтийн бус хөрөнгө	-	-
Үндсэн хөрөнгө (цэвэр)	720,473.15	720,473.15
Биет бус хөрөнгө	59,457,831.00	59,457,831.00
Нийт эргэлтийн бус хөрөнгө	60,178,304.15	60,178,304.15
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,124,948,840.61	1,122,674,750.77
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
Өр төлбөр	-	-
Богино хугацаат өр төлбөр	631,223,548.74	635,678,548.74
Урт хугацаат өр төлбөр	438,736,580.18	438,736,580.18
Нийт өр төлбөр	1,069,960,128.92	1,074,415,128.92
Эздийн өмч	-	-
Дүрмийн сан	1,874,229,573.44	1,874,229,573.44
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	199,260,985.77	199,260,985.77
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(2,018,501,847.52)	(2,025,230,937.36)
Нийт эздийн өмч	54,988,711.69	48,259,621.85
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,124,948,840.61	1,122,674,750.77

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2025 оны 12 сарын 31-ний байдлаар

	(төгрөгөөр)	
	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Борлуулалтын орлого	-	-
Борлуулалтын өртөг	-	-
Нийт ашиг (алдагдал)	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	22,205,178.83	7,191,000.00
Бусад зардал	-	-
Бусад олз (гарз)	(131,747.95)	461,910.16
Бусад ашиг (алдагдал)	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(22,336,926.78)	(6,729,089.84)
Орлогын татварын зардал	-	-
Татварын дараах ашиг (алдагдал)	(22,336,926.78)	(6,729,089.84)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(22,336,926.78)	(6,729,089.84)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Орлогын нийт дүн	(22,336,926.78)	(6,729,089.84)
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 12 сарын 31-ний байдлаар

	(төгрөгөөр)			
	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2024 оны 12 сарын 31	1,874,229,573.44	199,260,985.77	(2,018,501,847.52)	54,988,711.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	1,874,229,573.44	199,260,985.77	(2,018,501,847.52)	54,988,711.69
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(6,729,089.84)	(6,729,089.84)
2025 оны 12 сарын 31	1,874,229,573.44	199,260,985.77	(2,025,230,937.36)	48,259,621.85

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салиг үй хэсэг болно.



МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 12 сарын 31-ний байдлаар

	(төгрөгөөр)	
	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	-	-
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	-	-
Мөнгөн зарлагын дүн	3,632,778.83	2,736,000.00
Татварын байгууллагад төлсөн	-	-
Зохицуулалтын хөлс шимтгэл, хураамжид төлсөн	3,600,980.00	2,736,000.00
Бусад мөнгөн зарлага	31,798.83	-
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,632,778.83)	(2,736,000.00)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгөн орлогын дүн	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
Мөнгөн зарлагын дүн	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгөн орлогын дүн	-	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Мөнгөн зарлагын дүн	131,747.95	461,910.16
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	131,747.95	461,910.16
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(131,747.95)	(461,910.16)
Валютын ханшийн зөрүү	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(3,764,526.78)	(2,274,089.84)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,177,097.95	14,412,571.17
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,412,571.17	12,138,481.33

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.





**ДӨЛГӨӨН ХАЙРХАН УУЛ
АУДИТ ХХК**

Нягтлан бодох бүртгэл, аудит, санхүүгийн
хөндлөнгийн хяналтын байгууллага

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороолол
Ногоон нуур гудамж, 101 барилгын 1204 тоот
Утас: (976) 99055711, 99038602, 70005711
E-mail: dulguunhairhan_audit@mongol.net

2026.04.29 № 26/0464

танай _____-ны № _____-т

УДИРДЛАГАД ХҮРГЭХ ЗАХИДАЛ

“Евразиа капитал холдинг ҮЦК” ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланд аудит хийх явцад бидний анхаарлыг татсан санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системийг сайжруулах тухай асуудлуудыг энэхүү тайланд багтаасан болно.

Дотоод хяналтын системийн талаар гүйцэтгэсэн горим нь тус компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх болон уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланд аудит хийхтэй холбоотойгоор хяналтын орчны талаар ойлголт авах явдлаар хязгаарлагддаг билээ. Иймд энэхүү горимыг гүйцэтгэх явцад бидний анхааралд өртсөн тодорхой зүйлүүдийг удирдлагад хүргэх зорилгоор энэхүү тайланг толилуулав.

Бидний хийсэн энэ шалгалтын горим нь хяналтын бүх процедур ба аргачлалыг тодорхойлж, дэлгэрэнгүй буюу нарийвчилсан зөвлөмж, заавар өгөх зорилгогүй юм.

Энэхүү тайланг зөвхөн компанийн удирдлагад зориулан бэлтгэснээс бус өөр бусад зорилго агуулаагүй болно.

Тайланд бичигдсэн эдгээр зөвлөмжүүдийн талаар ярилцах эсвэл тэдгээрийг хэрэгжүүлэх ажилд туслахад бид бэлэн байх болно.

Санхүүгийн тайланд аудит хийх явцад танай компанийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлд ажиглагдсан зөрчил дутагдал, түүнийг цаашид засч залруулах, сайжруулах талаар бидний өгсөн дараах зөвлөмжүүдийг ажил хэрэг болгоход анхаарч ажиллана гэдэгт итгэж байна.

Энэхүү аудитын ажилд хамтран ажилласан болон аудитын ажлын явцад туслалцаа үзүүлж байсан явдалд компанийн удирдлага, ажилтнуудад талархлаа илэрхийлье.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ:



Б. ПҮРЭВДУЛАМ



Бид санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системийг сайжруулахтай холбогдуулан дараах зөвлөмжүүдийг өгч байна.

Мөнгөн хөрөнгийн талаар:

Бодит байдал:

- 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд харилцах данс дахь 12,088.8 мянган төгрөгийн дансны үлдэгдлийг баталгаажуулах боломжгүй аудитаар илгээсэн тулган баталгаажуулалтанд хариу ирээгүй;

Эрх зүйн үндэслэл:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
 - **20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт:** Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага нь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" үүрэгтэй.
- Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт, *“Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”*

IV бүлэг – Санхүүгийн тайлангийн тодруулга

- 3. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө: Касс, банкны харилцах дансанд байгаа мөнгө, мөнгөтэй адилтгах хөрөнгийн эхний болон эцсийн үлдэгдлийг тодруулна.

Зөвлөмж:

- Байгууллагын санхүүгийн албанаас харилцах данстай тухайн банкинд яаралтай хандаж, 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон үлдэгдлийн тодорхойлолтыг албан ёсоор гаргуулан авч аудитын багт ирүүлэх.
- Хэрэв банкнаас тулган баталгаажуулах захидалд хариу өгөх хугацаа хэтэрсэн бол орлуулах горим болгож 2025 оны 12 дугаар сарын банкны эцсийн албан ёсны хуулга, тухайн өдрийн "Банкны тохируулгын тайлан" болон 2026 оны 1 дүгээр сарын эхний өдрүүдийн хуулгыг хавсарган аудиторт шалгуулж, бүртгэлийн дүнгээ нотлох.
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу сар бүр харилцах дансны үлдэгдлийг банкны хуулгатай заавал тулгаж, баталгаажуулж байх.
- Сангийн сайдын 361 дүгээр тушаалын зааврыг баримтлан, тайлангийн жилийн эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тодруулгад үнэн зөв тусгахын тулд тайлан баланс гаргахаас өмнө бүх банкны үлдэгдэл баталгаажуулах ажиллагааг бүрэн дуусгадаг тогтолцоонд шилжих.



Бодит байдал:

- Санхүүгийн тайлан дээрх дансны авлага 471,964.3 мянган төгрөг, өглөг 551,206.5 мянган төгрөг тулган баталгаажуулж тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, насжилтын тайлан бэлтгээгүй байна. Манайд ирүүлсэн бүртгэлийн чанарын болон цаг хугацааны улмаас аудитын горим ашиглан тулган баталгаажуулалт хийгээгүй болно.

Эрх зүйн үндэслэл:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
 - 12 дугаар зүйл. Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого: 12.1-д: "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна". 12.2-т: "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ" гээд 12.2.1-д: "Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэж заасан.
- Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт, *"Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"*

II бүлэг – Санхүү байдлын тайлан

- **1. Дансны өглөг:** Үүнд бизнесийн үндсэн үйл ажиллагааны явцад бэлтгэн нийлүүлэгчдээс худалдан авсан бараа, хангамжийн зүйлс, үйлчилгээний үнийн төлөгдөөгүй үлдэгдэл хамаарна.
- **2. Дансны авлага:** Үүнд аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах авлагын дүн орно. Дансны авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгөөр хүлээн авахаар тооцоолж буй цэвэр дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд харуулна.
- Сангийн сайдын 2017 оны 347-р тоот тушаалын хавсралт *"Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"*

VI бүлэг – Тооцооны маягтыг нөхөх

- НХМаягт ТМ-3 Харилцагч талуудын хооронд гарсан ажил гүйлгээг тодруулан тайлант үеийн эцэс дэх хоорондын тооцооны үлдэгдлийг баталгаажуулахдаа улирал, жилийн эцэст харилцагч талууд **тооцооны үлдэгдлийн баталгааг үйлдэнэ**. Шаардлагатай бол санхүүгийн тайлангийн дундуур хийж болно. Тооцооны үлдэгдлийн баталгааг тооцоо үүссэн данс тус бүрээр хөтлөнө. 2 байгууллагын тооцооны баримтыг тооцооны үлдэгдлийн баталгааны хавсралтад нэгтгэж гаргана.

Зөвлөмж:

- Дансны авлага, өглөгийн үлдэгдлийг харилцагч бүрээр задлан, тус бүрийн үлдэгдэл, үүссэн огноо, төлбөрийн нөхцөлийг тодорхой тусгасан дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх.
- Авлага, өглөг бүрийг анхан шатны баримтанд (гэрээ, нэхэмжлэх, акт) тулгуурлан баталгаажуулах.
- Авлага, өглөгийг хугацаагаар нь ангилсан (0–30 хоног, 31–90 хоног, 90-ээс дээш хоног гэх мэт) насжилтын тайланг сар, улирал, жилийн эцэст тогтмол гаргаж хэвших.
- Ингэснээр хугацаа хэтэрсэн өглөгийг хянах, удирдлагын шийдвэр гаргалтад ашиглах боломж бүрдэнэ.
- Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтын дагуу ТМ-3 маягтыг ашиглан харилцагч бүртэй улирал, жилийн эцэст тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах.
- Баталгаажуулсан актыг санхүүгийн баримтын бүрдэлд хадгалах.
- Цаашид аудитын шалгалтад шаардлагатай нотлох баримтыг бүрэн бүрдүүлэх (гэрээ, нэхэмжлэх, төлбөрийн баримт, тооцоо нийлсэн акт гэх мэт).
- Ингэснээр аудитын горимоор тулган баталгаажуулалт хийх боломжийг бүрдүүлж, санхүүгийн тайлангийн найдвартай байдлыг нэмэгдүүлнэ.



Бодит байдал:

- 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланд байгууллага **54,887.0 мянган төгрөгийн цалингийн өглөгтэй** гэж тайлагнасан бөгөөд үр дүнгийн тайланд цалингийн зардал тусгаагүй, нийгмийн даатгалд тайлагнаагүй байна. Энэ нь ажилтнуудад олгох ёстой цалин хөлс хугацаандаа олгогдоогүй, мөн үүссэн өглөгийн бүртгэл, төлөлтийн хуваарь тодорхой бус байгааг илтгэж байна.

Эрх зүйн үндэслэл:

- Хөдөлмөрийн тухай хуулийн Хоёрдугаар дэд бүлгийн 124 дүгээр зүйлийн 124.1: Ажил олгогч нь энэ хуулийн 104.1-д заасан өдөр ажилтанд цалин хөлс олгоогүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд олгох ёстой цалингийн *0.03 хувьтай тэнцэх алданги* тооцож ажилтанд нөхөн олгох үүрэгтэй.
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
 - **20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт:** Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага нь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" үүрэгтэй.

Зөвлөмж:

- Байгууллага нь ажилтнуудын цалин хөлсийг хуульд заасан хугацаанд тогтмол олгож, цалингийн өглөг үүсэх, удаашрах эрсдэлийг бууруулах дохиолол, хяналтын механизм бүрдүүлэх.
- Хугацаа хэтэрсэн цалин хөлсөнд холбогдох алданги, нөхөн төлбөрийг тооцох журмыг баталгаажуулж, Хөдөлмөрийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн мөрдөх.
- Цалингийн өглөгийн дансны үлдэгдлийг тогтмол тооцоо нийлж баталгаажуулах, тайлангийн үнэн зөв байдлыг хангах.
- Хэрэв өглөг бодитоор үүссэн бол Орлого үр дүнгийн тайланд цалингийн зардлыг "аккруэл" зарчмаар нөхөж бүртгэн, зардлаа бодитой харуулах.
- 54,886.9 мянган төгрөгийн цалингийн дүнгээр нийгмийн даатгал (НДШ) болон татварын тайлангуудыг нөхөн тайлагнаж, хуулийн дагуу залруулах.
- Ажилтнуудын цалингийн өрийг барагдуулах тодорхой хугацаатай төлөлтийн хуваарь гаргаж, удирдлагаар батлуулан мөрдөх.

АУДИТОР:

Ж.АЛТАНЦЭЦЭГ

(Мэргэшсэн нягтлан бодогч)